



**“МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ  
МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ  
2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

**“МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ  
МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 5-ны өдөр

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг судлан үзээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup>.5.2 дахь заалтыг үндэслэн Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс дараахь дүгнэлт гаргаж байна.

Зөвлөл дүгнэлт гаргахдаа өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.10-д заасан “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг”, 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 12.1-д тусгагдсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана” болон 12.3-д тусгагдсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга”-тай нийцсэн эсэх, Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсөв боловсруулах үзэл баримтлалд нийцтэй эсэхэд анхаарсан.

**1. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх талаар**

**1.1. Өөрчлөлт оруулах үндэслэл.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлага тавьж, Монгол Улсын 2025 оны төсвийн хуульд бүхэлд нь хориг тавьснаар Улсын Их Хурлаас уг хуулийг хүчингүй болгосон. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл болон бусад үзүүлэлтүүдийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгахаар заасан байдаг нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгосон байна.

**1.2. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх.** Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг тооцохдоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3.а-д заасны дагуу 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 129 ам.доллар байхаар төсөөлжээ. Үүнээс үзвэл төсвийн тэнцвэржүүлсэн үнээс шалтгаалж “төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж байна” гэж тус зөвлөлөөс өмнө өгч байсан дүгнэлтийг дахин анхааруулахад хүрч байна.

**1.3. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухай жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь 2025 онд ДНБ-ний 3.3 хувьтай, 2026-2027 онуудад 2 хувьтай тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангасан гэж үзжээ. Хэрэв

2025 онд гадаад дотоод хүчин зүйлийн улмаас эдийн засгийн идэвхжил суларч,<sup>1</sup> ДНБ-ний өсөлт 8 хувьд хүрэхгүй тохиолдолд тэнцвэржүүлсэн орлого буурах, нэгдсэн төсвийн суурь тэнцэл сөрөг гарах нөхцөл бүрдэхийг анхаарах шаардлагатай. Тухайлбал Төсвийн Тогтвортой байдлын Зөвлөлөөс 2024 оны 3 сарын 15-ны өдөр гаргасан макро эдийн засгийн төсөөлөлд эдийн засгийн өсөлтийг 2024 онд 5.4 -7.1 хувь, 2025 онд 5.9-6.7 хувь байхаар таамагласан. Макро эдийн засгийн бодит өсөлт 2024 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 5.6 хувь<sup>2</sup> байх таамаглал баталгаажихаар байна.

**1.4. Засгийн газрын өрийн нийт хэмжээ.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2025-2027 онуудад хуульд заасан хязгаарт буюу 55 хувь, 50 хувь, 45 хувь байхаар тус тус тооцоолжээ.

Засгийн газрын нийт өрийн хэмжээ 2023 оны гүйцэтгэлээр 30,773.5 тэрбум төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 35,206.2 тэрбум төгрөг, 2025 оны төсөөллөөр **5,286.8** тэрбум төгрөгөөр нэмэгдэж **40,493** тэрбум төгрөгт хүрэхээр төсөвлөсөн нь (танилцуулгын 21 дүгээр хуудас) ДНБ-ний 42.6 хувь болж эдгээр үзүүлэлтүүдийн хооронд зөрүү үүсгэж байна.

**1.5. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн таамаглал.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1.6</sup>-д “Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг энэ хуулийн 16<sup>1.5.1</sup>-д заасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулаагүй бол түүний үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлж тайлбарлан, уг тайлбарыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хамт өргөн мэдүүлнэ” гэсэн заалт хэрэгжээгүй хэвээр байна.

**1.6. Төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.3-т “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах агуулгатай” байна гэсэн заалтаас:

- 12.3.3 макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ;

- 12.3.8.өмнөх 2 жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл, төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл, улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалтын талаарх нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд тус тус тусгагдаагүй байна.

**2. Төсөв, макро эдийн засгийн тогтвортой байдал хангагдсан эсэх болон төсөв боловсруулах үзэл баримтлалд нийцтэй эсэх талаар**

**2.1. Макро эдийн засгийн үзүүлэлтийн өөдрөг төсөөлөл.** Өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдсан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад ДНБ-ний өсөлтийг ирэх онд 8, инфляцыг 7.2 хувиар тооцсон хэдий ч нэрлэсэн дүнгээр ДНБ-ний хэмжээ

<sup>1</sup> Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн энэхүү хуулийн төслийн танилцуулганд “геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удааших, инфляц төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй хэвээр байна.” гэж дурдсан байна.

<sup>2</sup> Эдийн засгийн бодит өсөлт (ДНБ) 2024 оны 3 улирлын гүйцэтгэлээр 5.0 хувь гарсан.(ҮСХ)

95,010.0 тэрбум орчим буюу өсөлт нь 20 хувь орчим байхаар тооцсон нь эдийн засгийн гадаад, дотоодын орчны өнөөгийн байдалтай уялдуулан үзэхэд хэт өөдрөг хэвээр байна. Аливаа эдийн засгийн хувьд нэрлэсэн ДНБ-ний өсөлт нь бодит өсөлт, инфляцын нийлбэртэй ойр байдаг буюу өнөөгийн тохиолдолд 20 хувийн өсөлт биш  $8 \text{ хувь} + 7.2 \text{ хувь} = 15.2 \text{ хувийн}$  өсөлтийг хүлээх нь оновчтой гэж үзэж байна.

Хүснэгт: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн талаарх Олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас гаргасан таамаглал

Үзүүлэлт	2006-2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2029
ДНБ-ний бодит өсөлт	8.0	1.5	5.6	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.4	5.5	<b>7.0</b>	<b>5.0</b>
ХҮИ	10.9	0.8	4.3	6.8	7.3	3.7	7.4	15.2	10.3	6.5	<b>9.0</b>	<b>6.6</b>

Эх сурвалж: ОУВС “Дэлхийн эдийн засгийн төлөв байдал 2024 оны 10 сар.” Хуудас 119

**2.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 8 сард оруулсан нэмэлт өөрчлөлтийг эргэн харах нь зүйтэй болохыг харуулж байна.** Тус өөрчлөлтөөр тус хуулийн 12.1. “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана” заалтыг өөрчлөн найруулахдаа

- 12.1.3.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын **доод** хэмжээ;
- 12.1.4.нэгдсэн төсвийн нийт зарлагын **дээд** хэмжээ;
- 12.1.6.нэгдсэн төсвийн суурь зарлагын **дээд** хэмжээ;

гэсэн нь мөн хуулийн

- 4.1.6."нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл" гэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн нийт зарлагын зөрүүг;
- 4.1.12.“нэгдсэн төсвийн суурь зарлага” гэж нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцсон дүнг;
- 4.1.13.“нэгдсэн төсвийн суурь тэнцэл” гэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос суурь зарлагыг хассан дүнг

гэсэн заалтуудтай нийцэх албагүй нөхцөл байдлыг буюу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээрх үзүүлэлтүүд хоорондоо нийцгүй байх боломжийг үүсгээд байна. Үүнээс үүдэн төсөв дагаагүй Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, түүнд хяналт тавихад хүндрэл үүсэхээр байна. Иймд төсвийн хүрээний мэдэгдлийг бэлтгэхдээ нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ, нэгдсэн төсвийн суурь зарлагын хэмжээ гэсэн нэршлийг ашиглах шаардлагатай.

**2.3. Төсвийн алдагдал, эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлого.** Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар тооцоолон оруулж ирсэн нь сайшаалтай боловч ирэх онд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ төлөвлөж байснаар биелэгдэхгүй тохиолдолд нийт тэнцвэржүүлсэн алдагдал бий болох магадлалтай. Иймд аль болох төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг эерэг гаргах нь цаашид бодит утгаар улсын төсвийг алдагдалгүй байлгах зорилтыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Нөгөө талаар эдийн засгийн мөчлөг дагасан бодлого нь өргөн мэдүүлсэн Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд хэвээр хадгалагдаж байгааг анхаарч цаашдаа эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлогын бодитой суурийг тавих шаардлагатай гэж Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс үзэж байна.

## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ